



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/571

Номгон

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ,
хугацааг даатгуулагч (иргэн)-д тогтоосон байдалд
хяналт, шалгалт хийх тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 а, к, 29.2, 29.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Хяналт шалгалтын аян зохион байгуулах тухай" А/120 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны "Дэд ажлын хэсэг байгуулах тухай" А/106 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоосон байдалд хяналт, шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, ажлын хэсгийн хяналт шалгалт, долоо хоног бүрийн явцын тайланг удирдамжид заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажлын дэд хэсэгт хүргүүлж ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын Улсын байцаагч (Д.Амарсайхан)-д үүрэг болгосугай.

3. Хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнд хяналт шинжилгээ хийж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601710337

Аймгийн Засаг даргын _____ он _____ сарын
12... өдрийн 4571 захирамжийн _____ р хавсралт



ОРОН НУТГИЙН ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дэд ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхбаяр	Аймгийн Засаг даргын орлогч
Д.Мөнхбат	Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Д.Баасанцэрэн	Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
Л.Мөнхцацрал	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын нийгмийн халамжийн хэлтсийн дарга
Ж.Амарзаяа	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн Мэргэжилтэн
Г.Намнанжанцан	Нэгдсэн эмнэлгийн Чанарын албаны дарга
С.Урангоо	Мэргэжлийн хяналтын газрын Эмчилгээний чанар хариуцсан улсын байцаагч
Б.Молор-Эрдэнэ	Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн
Т.Ерэнбаяр	Эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад
Н.Цэдэвсүрэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв ТББ-ын тэргүүн

Нарийн бичгийн дарга:

Д.Амарсайхан Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн
хамгааллын хяналтын Улсын байцаагч